

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/14/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 51-260512 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 51-261628 Цахим хаяг: bujinkhandj@audit.gov.mn Аудитор: С.Болортуяа Утас: 261628 Цахим хаяг: bolortuyas@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.5.1 Төсвийн төлөвлөлт	17
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	18
3.5.3 Нэмэлт төсөв	19
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	19
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.5.1 Завсрын аудитын талаар	21
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ХБХХЕГ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
СЗСҮТ	Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төв
ХХХСҮТ	Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт үйлдвэрлэлийн төв
ХБИХЭДТ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв
ХБХСЗХТ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХЭДҮА	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа
ТББ	Төрийн бус байгууллага
САГ	Санхүүгийн аудитын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 795
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,905.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 1,520.9 сая төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэрлэх арга хэмжээ аваагүй;
- Харьяа байгууллагуудын авлагын үлдэгдэл өмнөх оноос 106.2 сая төгрөгөөр, өр төлбөр 249.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 15.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн

болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хуваарилалт", "нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 119.5 сая төгрөгийн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийн дагуу 1,078.5 сая төгрөгийн, нийт 1,198.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/53 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих өдрийн үйлчилгээний (Дэмжих төв) үнэ тариф"-г шинэчлэн тогтоосны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх дэмжих төвүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар зохион байгуулж, шаардлага хангасан 12 аж ахуй нэгж, байгууллагад нийт 3,902.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Бусад асуудал

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 чиглэл, 22 дэд зорилтын хүрээнд 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 88.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих зорилгоор Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 212 дугаар тогтоолоор Өмнөговь аймагт 7 дахь төвийг байгуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



О.МАГНАЙСҮРЭН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		6,059,123.2	6,644,159.0
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	2,352,489.1	2,970,555.6
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	3,706,634.0	3,673,603.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		26,112,423.6	28,392,175.1
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	26,112,423.6	28,392,175.1
Биет хөрөнгө		24,606,113.8	26,123,934.1
Биет бус хөрөнгө	13	1,506,309.8	2,268,241.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		32,171,546.8	35,036,334.1
НИЙТ ӨР ТӨЛБӨР		24,805.9	274,726.0
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		24,805.9	274,726.0
Өглөг		6,015.9	247,799.2
Урьдчилж орсон орлого	18а, 18б	18,790.0	26,926.8
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		32,146,740.9	34,761,608.1
Засгийн газрын хувь оролцоо		32,146,740.9	34,761,608.1
Засгийн газрын оруулсан капитал		9,639,448.8	9,639,448.8
Хуримтлагдсан үр дүн		17,018,751.1	19,633,618.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		5,488,541.1	5,488,541.1
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		32,171,546.8	35,036,334.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		29,594,600.6	35,604,035.9
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	4,285,608.1	35,604,035.9
Нийтлэг татварын бус орлого		-	29,739,165.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		25,308,992.5	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	29,155,549.3	32,989,372.6
УРСГАЛ ЗАРДАЛ		29,155,549.3	32,989,372.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		22,431,287.4	29,161,572.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		13,325,361.4	15,992,530.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,723,270.0	1,935,634.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		824,933.9	1,041,723.2
Хангамж, бараа материалын зардал		520,625.8	467,739.4
Норматив зардал		1,248,451.1	1,316,051.6
Эд хогшил, урсгал засварын зардал		471,623.5	240,006.2
Томилолт, зочны зардал		33,891.4	88,134.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		695,718.4	4,381,137.9
Бараа үйлчилгээний бусад зардал		3,587,411.8	3,698,615.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		6,724,261.9	3,827,800.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		439,051.3	2,614,663.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		102.6	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		59,901.1	205
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		(59,799.4)	(205)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		379,251.9	2,614,458.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	27,234,859.3	30,454,299.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	469,244.5	30,454,299.5
Нийтлэг татварын бус орлого	469,244.5	440,378.5
Тусламжийн орлого	-	30,013,921.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	26,765,614.8	-
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,857,221.6	30,263,985.1
УРСГАЛ ЗАРДАЛ	26,857,221.6	30,263,985.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,038,991.9	24,545,498.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,806,484.3	15,323,793.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,708,034.4	1,916,941.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	824,933.9	1,041,655.8
Хангамж, бараа материалын зардал	381,425.3	300,132.5
Норматив зардал	1,418,542.1	1,016,732.3
Эд хогшил, урсгал засварын зардал	633,621.2	228,830.1
Томилолт, зочны зардал	37,042.8	79,544.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	719,454.5	4,371,730.2
Бараа үйлчилгээний бусад зардал	509,453.5	266,138.7
ТАТААС	716,994.6	909,880.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,101,235.1	4,808,605.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	377,637.7	190,314.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	14,000.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	377,641.6	204,314.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	377,641.6	204,314.4
Дотоод эх үүсвэрээр	377,641.6	204,314.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(377,641.6)	(190,314.4)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(3.9)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3.9	-

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	31,748,516.1		31,748,516.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	18,972.9		18,972.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	31,767,489.0		31,767,489.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	379,251.9		379,251.9
Тайлант үеийн үр дүн	32,146,740.9		32,146,740.9
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	31,748,516.1		31,748,516.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	408.9		408.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	32,147,149.85		32,147,149.85
Тайлант үеийн үр дүн	2,614,458.3		2,614,458.3
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	34,761,608.15		34,761,608.15

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	32,852,941,200.00	26,304,833,261.77	6,548,107,938.23	80.1
12	Татварын бус орлого	32,852,941,200.00	26,304,833,261.77	6,548,107,938.23	80.1
120	Нийтлэг татварын бус орлого	535,000,000.00	440,378,462.55	94,621,537.45	82.3
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	490,000,000.00	398,194,692.30	91,805,307.70	81.3
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	45,000,000.00	42,183,770.25	2,816,229.75	93.7
122	Тусламжийн орлого	32,317,941,200.00	25,864,454,799.22	6,453,486,400.78	80.0
122001	Хандив тусламж /дотоод/	2,927,121,100.00	3,634,487,292.70	(707,366,192.70)	124.2
122005	Төсвөөс санхүүжих	29,390,820,100.00	22,229,967,506.52	7,160,852,593.48	75.6
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,852,941,200.00	25,430,809,356.47	7,422,131,843.53	77.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,852,941,200.00	25,430,809,356.47	7,422,131,843.53	77.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,451,849,700.00	24,223,096,958.90	7,228,752,741.10	77.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,750,681,700.00	15,282,714,830.60	2,467,966,869.40	86.1
210101	Үндсэн цалин	8,587,192,000.00	8,189,224,002.81	397,967,997.19	95.4
210102	Нэмэгдэл	5,117,280,900.00	3,928,699,338.19	1,188,581,561.81	76.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,626,987,900.00	2,056,567,939.91	570,419,960.09	78.3
210104	Урамшуулал	1,419,220,900.00	1,108,223,549.69	310,997,350.31	78.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,250,846,100.00	1,911,806,271.59	339,039,828.41	84.9
210201	Тэтгэврийн даатгал	1,538,743,000.00	1,324,176,252.60	214,566,747.40	86.1
210202	Тэтгэмжийн даатгал	178,250,000.00	152,654,711.42	25,595,288.58	85.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	89,639,300.00	81,587,138.62	8,052,161.38	91.0
210204	Ажилгүйдлийн даатгал	88,682,300.00	68,884,659.58	19,797,640.42	77.7
210205	Эрүүл мэндийн даатгал	355,531,500.00	284,503,509.37	71,027,990.63	80.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,344,920,500.00	1,041,655,773.98	303,264,726.02	77.5
210301	Гэрэл, цахилгаан	524,818,500.00	404,220,408.78	120,598,091.22	77.0
210302	Түлш, халаалт	576,415,100.00	472,586,196.55	103,828,903.45	82.0
210303	Цэвэр, бохир ус	235,292,700.00	156,449,168.65	78,843,531.35	66.5
210304	Байрны түрээс	8,394,200.00	8,400,000.00	(5,800.00)	100.1
2104	Хангамж, бараа материалын зардал	448,263,100.00	283,693,593.79	164,569,506.21	63.3
210401	Бичиг хэрэг	57,358,100.00	47,431,510.00	9,926,590.00	82.7
210402	Тээвэр, шатахуун	33,073,400.00	23,014,177.56	10,059,222.44	69.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	92,884,100.00	56,866,083.73	36,018,016.27	61.2
210404	Ном, хэвлэл	1,989,900.00	1,989,900.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	79,536,300.00	28,934,626.00	50,601,674.00	36.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	183,421,300.00	125,457,296.50	57,964,003.50	68.4
2105	Норматив зардал	1,784,143,300.00	1,014,128,896.30	770,014,403.70	56.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	931,041,100.00	519,527,676.30	411,513,423.70	55.8
210502	Хоол, хүнс	699,601,400.00	445,795,430.00	253,805,970.00	63.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	153,500,800.00	48,805,790.00	104,695,010.00	31.8

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	268,136,100.00	196,056,193.00	72,079,907.00	73.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	105,364,100.00	100,264,035.00	5,100,065.00	95.2
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	82,013,600.00	19,708,000.00	62,305,600.00	24.0
210604	Урсгал засвар	80,758,400.00	76,084,158.00	4,674,242.00	94.2
2107	Томилолт, зочны зардал	84,240,000.00	42,318,000.00	41,922,000.00	50.2
210702	Дотоод албан томилолт	84,240,000.00	42,318,000.00	41,922,000.00	50.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,411,722,500.00	4,363,240,251.64	3,048,482,248.36	58.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,246,801,600.00	4,329,591,516.80	2,917,210,083.20	59.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	41,803,300.00	7,150,100.00	34,653,200.00	17.1
210803	Даатгалын үйлчилгээ	12,079,900.00	808,024.00	11,271,876.00	6.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,646,000.00	1,613,911.00	1,032,089.00	61.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	4,654,700.00	356,000.00	4,298,700.00	7.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,705,500.00	13,513,872.84	23,191,627.16	36.8
210807	Газрын төлбөр	9,291,100.00	4,107,287.00	5,183,813.00	44.2
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	115,800.00	-	115,800.00	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	57,624,600.00	6,099,540.00	51,525,060.00	10.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,896,400.00	87,483,148.00	21,413,252.00	80.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800,900.00	800,850.00	50.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	108,095,500.00	86,682,298.00	21,413,202.00	80.2
212	ТАТААС	1,056,328,700.00	909,880,975.78	146,447,724.22	86.1
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,056,328,700.00	909,880,975.78	146,447,724.22	86.1
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,056,328,700.00	909,880,975.78	146,447,724.22	86.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	344,762,800.00	297,831,421.79	46,931,378.21	86.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	344,762,800.00	297,831,421.79	46,931,378.21	86.4
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	42,925,900.00	42,925,875.00	25.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	299,456,100.00	253,309,546.79	46,146,553.21	84.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,380,800.00	1,596,000.00	784,800.00	67.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	874,023,905.30	(874,023,905.30)	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(874,023,905.30)	874,023,905.30	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(874,023,905.30)	874,023,905.30	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,153	765	388	66.3
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	11	7	4	63.6
610001	Төсвийн байгууллага	1	7	4	63.6
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	504	382	122	75.8

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

620001	Удирдах ажилтан	18	15	3	83.3
620002	Гүйцэтгэх ажилтан	342	273	69	79.8
620003	Үйлчлэх ажилтан	141	93	48	66.0
620004	Гэрээт ажилтан	3	1	2	33.3
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	158	-	158	-
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	158	-	158	-
632001	Төрийн өмчит МСҮТ	158	-	158	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	469	368	101	78.5
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	25	-	25	-
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	26	26	-	100.0
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1	1	-	100.0
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	14	14	-	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	161	142	19	88.2
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	242	185	57	76.4
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	11	8	3	72.7
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	11	8	3	72.7

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	860,689,995.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	860,689,995.66
122	Тусламжийн орлого	860,689,995.66
1221	Хандив тусламж /дотоод/	860,689,995.66
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	860,689,995.66
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	18,605,000.00
350013	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	187,702,717.30
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61,865,000.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	592,517,278.36
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	534,216,314.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	534,216,314.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	524,216,314.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,079,037.20
210102	Нэмэгдэл	41,079,037.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,134,880.10
210201	Тэтгэврийн даатгал	2,475,394.40
210202	Тэтгэмжийн даатгал	1,427,116.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	205,394.60
210204	Ажилгүйдлийн даатгал	205,394.60

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	821,580.30
2104	Хангамж, бараа материалын зардал	27,502,708.00
210401	Бичиг хэрэг	90,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,482,278.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,930,430.00
2105	Норматив зардал	14,153,400.00
210502	Хоол, хүнс	14,153,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	184,309,578.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	70,908,555.00
210604	Урсгал засвар	113,401,023.00
2107	Томилолт, зочны зардал	37,226,150.00
210702	Дотоод албан томилолт	37,226,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,640,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,640,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	201,170,561.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,880,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	119,289,661.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,000,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	326,473,681.26
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(326,473,681.26)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(326,473,681.26)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх оролцоо, хөгжил хамгааллын талаарх Засгийн газрын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлж хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах, бие даан хөгжих чадварыг эзэмшүүлэх замаар амьдралын чанарыг нь дээшлүүлэхэд оршино.

ХБХХЕГ нь холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийн талаарх зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн оролцох, ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх эерэг ойлголт, хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх, тэдэнд ээлтэй нийгмийн орчин бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг чиглүүлэх, төрийн үйлчилгээг хуулийн дагуу, иргэдэд ээлтэй, хариуцлагатай, мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэхэд салбар дундын уялдаа холбоог хангах, удирдлага арга зүйн дэмжлэг тусалцаа үзүүлэх чиг үүрэгтэй ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

ХБХХЕГ нь үйл ажиллагаандаа Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын багц хууль, Боловсролын тухай багц хуулиуд, Гэр бүлийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуулиудыг мөрдлөг болгон хэрэгжүүлдэг байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 8, 12, 14, 16, 28, 57, 68, 70 дугаар зүйлүүдэд 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан
- Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” 43 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоол

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцсан бөгөөд дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ХБХХЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үндэслэн холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/136 дугаар тушаалаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлан, мөрдөн ажиллажээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ХБХХЕГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын 2015 оны А/341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 35,036.3 сая төгрөг болж, өмнөх оноос 2,864.8 сая төгрөгөөр буюу 10.8 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	2,352,489.1	2,970,555.6	618,066.5
Бараа материал	3,706,634.0	3,673,603.3	(33,030.7)
Үндсэн хөрөнгө	26,112,423.6	28,392,175.1	2,279,751.5
Нийт хөрөнгө	32,171,546.8	35,036,334.1	2,864,787.3
Өглөг	6,015.9	247,799.2	241,783.3
Урьдчилж орсон орлого	18,790.0	26,926.8	8,136.8
Засгийн газрын хувь оролцоо	32,146,741.0	34,761,608.2	2,614,867.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	32,171,546.8	35,036,334.1	2,864,787.3

Эх сурвалж: ХБХХЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, урьдчилж орсон орлого, засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Тухайлбал:

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлгүй байна.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудын мөнгөн хөрөнгийн дансны зарцуулалттай холбоотой нийт 321.6 сая төгрөгийн зөрчил илэрчээ. Тухайлбал:

- ХБХХЕГ-ын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Үндэсний зөвлөлийн гишүүдийн урамшууллын нийгмийн даатгалын шимтгэлийн 9.4 сая төгрөгийг зардлыг үндсэн цалин хөлсний зардлаас эдийн

- засгийн ангилал зөрчин зарцуулсан; /ХБХХЕГ/
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор хүүхдүүдэд танхимаар үзүүлэх өдрийн үйлчилгээ аваагүй 5 хүүхдийн 8.3 сая төгрөгийн санхүүжилтийг "Бяцхан гэрэлт цох" цэцэрлэгт олгосон, мэдээлэл, технологийн асуудал хариуцсан мэргэжилтэнд ажилласны хугацаанд 8.2 сая төгрөгийг унаа, хоолны хөнгөлөлтийг олгоогүй, 7.0 сая төгрөгөөр зардлын эдийн засгийн ангилал зөрчин тайлагнасан; /ХБХХЕГ/
- Архангай ХБХХТөв нь унаа хоолны хөнгөлөлтийн зардлын батлагдсан төсвийг 10.5 сая төгрөгөөр хэтрүүлсэн, ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан 39.1 сая төгрөгийг олгосон;
- ХБХСЗХТ-ийн даргын А/92 дугаар тушаалаар Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврыг зөрчин 16.9 сая төгрөгийн дотоод албан томилолтын зардал олгосон; /ХБХСЗХТ/
- Ховд аймаг дахь ХБХХТөв нь түлш халаалтын зардлаас тээвэр шатахууны зардлыг 7.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн;
- Ажилчдын цалин, урамшуулал, нэмэгдлийг илүү тооцож олгосон, сахилгын шийтгэлтэй ажилчдад үр дүнгийн урамшуулал олгосон, хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу суутгасан 178.1 сая төгрөг; /СЗСҮТ 55.8 сая төгрөг, ХБХСЗХТ 34.5 сая төгрөг, Дархан-Уул аймгийн ХБХХТөв 33.9 сая төгрөг, Хөвсгөл аймгийн ХБХХТөв 18.6 сая төгрөг, Дорнод аймгийн ХБХХТөв 16.7 сая төгрөг, ХБИХЭДТ 11.7 сая төгрөг, ХХХСХХТ 5.3 сая төгрөг, Дундговь аймгийн ХБХХТөв 1.6 сая төгрөг/
- Цахим төлбөрийн и баримтгүй 8.7 сая төгрөгийн худалдан шууд худалдан авалт хийсэн /ХБИХЭДТ/
- Томилолтын зарцуулалтыг урьдчилгаа тооцоогоор тайлагнаагүй, гүйцэтгэлийг хянаагүй, цахим төлбөрийн 18.7 сая төгрөгийн и баримтгүй. /ХБИХЭДТ/

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 2,970.5 сая төгрөг болж, өмнөх оноос 618.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	24,287.2	31,267.6	6,980.4
Төлбөртэй үйлчилгээний авлага	286,402.6	384,520.4	98,117.8
Татаас санхүүжилтийн авлага	376,973.1	978,606.6	601,633.5
Байгууллагаас авах авлага	-	1,117.8	1,117.8
Дансны авлага /ТӨҮГ/	66,009.7	682.6	(65,327.1)
Хувь хүмүүсээс авах авлага	46,514.7	36,058.8	(10,455.9)
Зээлийн авлага	1,552,301.6	1,538,301.6	(14,000.0)
Дүн	2,352,489.1	2,970,555.6	618,066.5

Эх сурвалж: ХБХХЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл өмнөх оноос 618.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ажиллагчидтай холбоотой авлага 7.0 сая төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас авах төлбөртэй үйлчилгээний авлага 98.1 сая төгрөг, татаас санхүүжилтийн авлага 601.6 сая төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Зээлийн авлагын үлдэгдэл 1,538.3 сая төгрөг болж өмнөх оноос 14.0 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудын авлагын данстай холбоотой нийт 42.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- “Файбер троника” ХХК-ас авах авлагыг 41.3 сая төгрөгийн протезын түүхий эдээр барагдуулан тооцоог хаасныг цахим төлбөрийн и-баримтаар баталгаажуулаагүй. /СЗСҮТ/
- Өмнөх онуудад үүссэн бэлтгэн нийлүүлэгчээс авах 1.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй. /ХХХСХТ/

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 3,673.6 сая төгрөг болж, өмнөх оноос 33.0 сая төгрөгөөр буурчээ.

Хүснэгт 3. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	787,324.4	766,882.4	(20,442.0)
Тусгай зориулалттай материал	461,443.1	458,369.0	(3,074.1)
Эм боох материал	325,881.2	308,513.3	(17,367.9)
Дуусаагүй үйлдвэрлэл	71,844.8	110,750.6	38,905.8
Бэлэн бүтээгдэхүүн	34,611.5	49,576.8	14,965.3
Хангамжийн материал	2,812,853.3	2,746,393.5	(66,459.8)
Бичиг хэргийн материал	20,879.3	10,765.0	(10,114.3)
Аж ахуйн материал	35,553.3	32,431.0	(3,122.3)
Сэлбэг хэрэгсэл	2,162.0	3,252.0	1,090.0
Түлш, шатах тослох материал	7,609.4	1,307.7	(6,301.7)
Барилгын засварын материал	4,190.9	3,866.9	(324.0)
Хүнсний материал	123,085.8	43,498.9	(79,586.9)
Бусад хангамжийн материал	2,619,372.3	2,651,272.0	31,899.7
Дүн	3,706,634.0	3,673,603.3	(33,030.7)

Эх сурвалж: ХБХХЕ-ЫНГ 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын үлдэгдлийн 75.0 хувийг хангамжийн материал, 21.0 хувийг түүхий эд материал, 1.0 хувийг бэлэн бүтээгдэхүүн, дуусаагүй үйлдвэрлэл 3.0 хувийг эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,689.4 сая төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 104.0 сая төгрөгийн, шилжүүлсэн авсан 462.6 сая төгрөг, нийт 2,256.1 сая төгрөгөөр бараа материал нэмэгдэж, үйл ажиллагаанд зарцуулсан 2,073.6 сая төгрөгийн, акталсан 1.4 сая төгрөгийн, шилжүүлсэн 214.2 сая төгрөгийн, нийт 2,289.1 сая төгрөгийн бараа материал хасагдсан.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудын бараа материалын данстай холбоотой нийт 96.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Тайлант онд үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй, нийт 92.1 сая төгрөгийн бараа материал нөөцөлж худалдан авсан. /ХБХСЗХТ/
- Бараа материалын дансанд ашиглалтын хугацаа дууссан 2.7 сая төгрөгийн эм, эмийн бэлдмэл, аудитын явцад хийсэн хяналтын тооллогоор 1.3 сая төгрөгийн эмийн материал зөрүүтэй, бараа материалын агуулах эмх цэцгүй хөрөнгийн нэр, маркийг бичиж хаягжуулаагүй. /СЗСҮТ/

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 28,392.2 сая төгрөг болж, өмнөх оноос 2,279.7 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Хүснэгт 4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	24,606,113.8	26,123,934.1	1,517,820.3
Барилга, байгууламж, орон сууц	12,289,278.1	13,132,635.9	843,357.8
Авто-тээврийн хэрэгсэл	266,417.0	487,980.2	221,563.2
Машин тоног төхөөрөмж(компьютер)	9,996,562.5	10,569,209.2	572,646.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,931,430.5	1,825,726.6	(105,703.9)
Бусад үндсэн хөрөнгө	114,220.5	100,382.1	(13,838.4)
Номын фонд	8,205.0	8,000.0	(205.0)
Биет бус хөрөнгө	1,506,309.8	2,268,241.0	761,931.2
Программ хангамж	290,431.7	22,472.9	(267,958.8)
Бусад биет бус хөрөнгө	1,215,878.0	2,245,768.1	1,029,890.1

Дүн	26,112,423.6	28,392,175.1	2,279,751.5
-----	--------------	--------------	-------------

Эх сурвалж: ХБХХЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгийн 46.2 хувийг барилга, байгууламж, 6.4 хувийг тавилга эд хогшил, 37.2 хувийг тоног төхөөрөмж, 1.7 хувийг авто тээврийн хэрэгсэл болон бусад үндсэн хөрөнгө, 8.0 хувийг биет бус хөрөнгө, тус тус эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 212.0 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандиваар 477.6 сая төгрөгийн, шилжүүлэн авсан 4,965.2 сая төгрөгийн, нийт 5,654.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 111.5 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 209.8 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, нийт 321.3 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасалт хийсэн. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 3,053.7 сая төгрөгөөр нэмэгджээ.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгийн данстай холбоотой нийт 1,650.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 1,520.9 сая төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэрлэх арга хэмжээ аваагүй; /ХБХСЗТ/
- Хөрөнгө оруулалтын төсөв батлуулаагүй нийт 79.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн; /ХБИХЭДТ/
- Ашиглалтын шаардлага хангахгүй 23.6 сая төгрөгийн хөрөнгүүд бараа материалын дансанд, технологийн хоцрогдолд орсон, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдахгүй 4.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн дансанд тус тус бүртгэлтэй; /ХХХСХТ/
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны А/1/1981 дугаар зөвшөөрлийн дагуу 21.7 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг 2022 онд холбогдох байгууллагад хүлээлгэн өгсөн боловч 2023-2024 онуудын жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллыг үнэн зөв хийгээгүйгээс тус хөрөнгөнд хуримтлагдсан элэгдэл тооцсон. /ХБХХЕГ/

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 247.8 сая төгрөг болж, өмнөх оноос 241.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Өглөг	6,015.8	247,799.2	241,783.4
Ажилчидтай холбогдсон өглөг	5,241.6	-	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	40,451.3	40,451.3
Бусад өглөг	774.2	207,347.8	206,573.6
Хувь хүмүүст төлөх өглөг	-	206,379.5	206,379.5
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,015.8	247,799.2	241,783.4

Эх сурвалж: ХБХХЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдлийн 93.0 хувь буюу 231.0 сая төгрөгийг СЗСҮТ, ХБХСЗХТ, Хөвсгөл аймгийн ХБХХТ, Архангай аймгийн ХБХХТ-ийн эм, эмнэлгийн хэрэгслийн өглөг, 16 хувь буюу 16.0 сая төгрөгийг ХБИХЭДТ, ХБХХЕГ, Архангай аймгийн ХБХХТ, Ховд аймгийн ХБХХТ, Дархан-уул аймгийн ХБХХТ-ийн өр төлбөр тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудын өр төлбөртэй холбоотой нийт 110.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Тайлант онд төлбөрийг хугацаанд төлж барагдуулаагүйгээс 108.8 сая төгрөгийн, “ГХГБ Ундрага” ХХК-тай байгуулсан худалдан авах гэрээний үнийн дүнгээс 2.0 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн илүү орлого авч тус тус өр төлбөр үүсгэсэн. /ХБХСЗХТ 108.8 сая төгрөг, СЗСҮТ 2.0 сая төгрөг/

3.4.6 Урьдчилж орсон орлого

Урьдчилж орсон орлогын дансны эцсийн үлдэгдэл 26.9 сая төгрөг болж, өмнөх оноос 8.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Урьдчилж орсон орлогын үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж орсон орлого	18,790.0	26,926.8	8,136.8
Бусад урьдчилж орсон орлого	18,790.0	26,926.8	8,136.8
Дүн	18,790.0	26,926.8	8,136.8

Эх сурвалж: ХБХХЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж орсон орлогын дансны үлдэгдэл өссөн нь СЗСҮТ-ийн дүүргийн халамжийн хэлтсээс протез, ортопедийн төлбөр урьдчилж авсантай холбоотой байна.

3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 34,761.6 сая төгрөг болж, өмнөх оноос 2,614.9 сая төгрөгөөр нэмэгдэж 10.8 хувиар өсжээ.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо / мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	9,639,448.7	9,639,448.7	-
Хуримтлагдсан үр дүн	17,018,751.2	19,633,618.4	2,614,867.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,488,541.0	5,488,541.0	-
Дүн	32,146,740.9	34,761,608.1	2,614,867.2

Эх сурвалж: ХБХХЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,614.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн голлон нөлөөлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

ХБХХЕГ нь 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 37,108.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, улсын төсвөөс 33,646.6 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих 2,927.1 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 0.5 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 45.0 сая төгрөг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Тайлант онд төсвийн зохицуулалт хийгдэж төсвийн төслийн саналаас 1,354.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 38,463.4 сая төгрөгөөр баталжээ.

Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 07 дүгээр сарын 09-ны өдрийн 01/2369 тоот албан бичгээр төсвийг тодотгон, батлагдсан төсвийг 5,387.1 сая төгрөгөөр бууруулсан бөгөөд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 33,076.3 сая төгрөг тодотгосон.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчаас төсөв хооронд зохицуулалт хийснээр ХБХХЕГ-ын 2025 оны төсвийг 32,852.9 сая төгрөгөөр баталж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 29,380.8 сая төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангаас 2,927.1 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 535.0 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 25,518.7 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 3,634.5 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус авч, үндсэн үйл ажиллагааны 440.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 8. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/ мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Орлогын төлөвлөгөө	Орлогын гүйцэтгэл	Зөрүү /давсан-, тасарсан+/
Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт үйлдвэрлэлийн төв	360,000.0	214,983.8	(145,016.2)
Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төв	145,000.0	168,122.7	23,122.7
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв	30,000.0	55,871.0	25,871.0
Дорнод. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв	-	30.0	30.0
Хөвсгөл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв	-	35.0	35.0
Дархан-Уул. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв	-	485.0	485.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв	-	851.0	851.0
Дүн	535,000.0	440,378.5	(94,621.5)

Эх сурвалж: ХБХХЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг нийт 94.6 сая төгрөгөөр тасалсан ба үүнээс ХХХСҮТ-ийн орлогын төлөвлөгөө 145.0 сая төгрөгөөр тасалсан голлон нөлөөлсөн. Энэ нь тайлант хугацаанд байрны засвар хийсэнтэй холбоотой сургалт зохион байгуулах боломжгүй байдал үүссэнтэй холбоотой.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэх зардлыг 32,852.9 сая төгрөгөөр төлөвлөснөөс 25,430.8 сая төгрөгийг зарцуулж 77.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Энэ нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 4,639.1 сая төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 46.9 сая төгрөгөөр, нийгмийн бүлэгт чиглэсэн зардлыг 2,736.1 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
72206	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	32,852,941.2	25,430,809.4	7,422,131.8	77.4
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	25,869,930.9	21,230,808.9	4,639,122.0	82.1
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	344,772.8	297,831.4	46,941.4	86.4
83115	Нийгмийн бүлэгт чиглэсэн	6,638,237.5	3,902,169.1	2,736,068.4	58.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

- Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 20-ний өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газрын орон тооны хязгаарыг 595

орон тоогоор баталснаас 10.9 хувиар буюу 65 орон тоогоор бууруулж, 530 байхаар баталжээ.

- ХБХХЕГ-ын харьяа байгууллагын тайлант онд унаа хоолны хөнгөлөлтийн зардалд 2,627.0 сая мянган төлөвлөж, гүйцэтгэлээр 2,056.6 төгрөгийг зарцуулж, 570.4 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь бүтэц орон тоо буурсантай холбоотой;
- Тайлант хугацаанд сургалт, семинарын зардалд 43 сургалтад нийт 75.9 сая зарцуулсан;
- ХБХХЕГ-ын харьяа 2 байгууллагаас төрд учирсан хохирлыг барагдуулах зардалд нийт 7.2 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байгууллагын төсвөөс төлж авлага үүсгэсэн.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайланд онд нэмэлт санхүүжилтээр төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 592.5 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 61.9 сая төгрөг, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 187.7 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн 18.6 сая төгрөгийн, нийт 860.7 сая төгрөгийн орлого бүрдүүлэн, үйл ажиллагаандаа 534.2 сая төгрөгийг зарцуулж, 326.5 сая төгрөгийг улсын орлогод төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

ХБХХЕГ нь тайлант онд 5 нэр төрлийн төсөл, арга хэмжээг төлөвлөн, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын дагуу зохион байгуулж 39 аж ахуйн нэгж, байгууллагатай нийт 6,251.7 сая төгрөгийн гэрээ байгуулжээ. Үүнд:

- Харуул, хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх 6 аж ахуйн нэгж, байгууллагатай 292.3 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ;
- Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх 10 аж ахуйн нэгж, байгууллагатай 384.2 сая төгрөгийн гэрээ;
- Хоол, хүнс ханган нийлүүлэх ажил, үйлчилгээг 9 аж ахуйн нэгж, байгууллагатай 539.0 сая төгрөгийн гэрээ;
- Нормын хувцас, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх 2 аж ахуйн нэгж, байгууллагатай 30.0 сая төгрөгийн гэрээ;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх ажил, үйлчилгээг 25 аж ахуйн нэгж, байгууллагатай 5,006.2 сая төгрөгийн гэрээг тус тус байгуулсан.

Аудитын илрүүлэлт: Харьяа байгууллагуудад худалдан авах ажиллагаатай холбоотой нийт 325.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн.Тухайлбал:

- Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээгүй, нийт 263.9 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авалт хийсэн; /ХБХСЗХТ/
- Тайлант онд 62.0 сая төгрөгийн түүхий эд материалын шууд худалдан авалт хийж, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. /ХХХСХТ/

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу ХБХХЕГ-ын 2025 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд ХБХХЕГ-ын төсвийн төвлөрүүлэн захирагч, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар

ХБХХЕГ-ын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өр төлбөр, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитор С.Болортуяа нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

ХБХХЕГ-ын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн 1/202 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 29,215.3 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 292.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага ямар нэгэн тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой зөрчлийг арилгах нийт 4,691.7 сая төгрөгийн зөрчилд илэрснээс 5.9 сая төгрөгийн 5 албан шаардлага, 4,685.9 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын илрүүлэлт:

- Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих зарим мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцроосон, зөрчлийг давтан гаргасан, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй 4,691.7 сая төгрөг; /Дархан-Уул аймгийн ХБХХТөв 3,249.9 сая төгрөг, ХБИХЭДТ 1,394.4 сая төгрөг, Дорнод аймгийн ХБХХТөв 41.5 сая төгрөг, ХБХХЕГ 5.9 сая төгрөг/

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хуулийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ХБХХЕГ-ын харьяа 11 байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 81 алдаа зөрчил илэрснээс санхүүгийн тайлантай холбоотой 361.8 сая төгрөгийн 21 алдаа, 2,549.4 сая төгрөгийн 52 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 4,691.7 сая мянган төгрөгийн 8 зөрчил илэрсэн нь төсвийн төвлөрүүлэн захирагчаас санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-т "хариуцлагатай байх", 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх," 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх," 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй зөрчлийг таслан зогсоож, алдаа зөрчлийг 15-аас доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

ХБХХЕГ-ын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудад нийт 8.5 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулж, 730.3 сая төгрөгийн 12 албан шаардлага хүргүүлснээс 254.9 сая төгрөгийн 9 албан шаардлагыг бүрэн биелүүлж, 2.6 сая төгрөгийн 23 зөвлөмж өгснөөс 1.6 сая төгрөгийн 16 зөвлөмжийг хэрэгжүүлж, аудитын шийдвэрийн хэрэгжилт 82.0 хувьтай байна.

Хүснэгт.10 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	6	8,518.9	6	8,518.9	100.0
Албан шаардлага	12	730,332.4	9	254,966.1	74.7
Зөвлөмж	23	2,561,463.4	16	1,326,510.5	71.3
Дүн	44	1,933,386.6	31	1,589,995.5	82.0

Өмнөх оны аудитаар өгсөн аудитын шийдвэрээс дараах зөрчлийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- ХБХХЕГ-ын 1 аж ахуйн нэгжид протезын үйлдвэрийг дэмжих зорилгоор олгосон зээлийн эргэн төлөлт хийгдээгүй хугацаа хэтэрсэн зөрчилд өгсөн албан шаардлага хэрэгжээгүй;

- ХБХХСЗТ-н барилгыг санхүүгийн тайлан данс бүртгэлд тусгуулахаар өгсөн албан шаардлага хэрэгжээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар орлогын төлөвлөлт, үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал, өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтэд горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлан, нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 361.8 сая төгрөгийн 21 алдааг илрүүлж аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 2,905.5 сая төгрөгийн зөрчил илэрч, 17.9 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоож, 2,310.3 сая төгрөгийн зөрчилд 25 албан шаардлага хүргүүлж, 577.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 21 зөвлөмжийг өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,905.5 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,613.4 сая төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газрын харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ХБХХЕГ-ын харьяа 11 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 11 байгууллагад дүгнэлт гаргасан байна.

Аудитад хамрагдсан харьяа 11 байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” 4, “Хязгаарлалттай” 7 (ХБХХЕГ, Архангай ХБХХТөв, Дархан-Уул аймгийн ХБХХТөв, ХХХСХТ, ХБИХЭДТ, ХБХСЗХТ, СЗСҮТ) дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 361.8 сая төгрөгийн 21 алдааг илрүүлж аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 2,549.4 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 17.8 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоож, 2,310.3 сая төгрөгийн зөрчилд 25 албан шаардлага хүргүүлж, 221.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 19 зөвлөмж өгсөн.

5.2. Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 356.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах 2 зөвлөмжийг өгсөн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын авлага дансны үлдэгдэл өмнөх оноос 106.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын үр дүнтэй хэрэгжүүлэн, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, авлагыг 30-оос доошгүй хувиар бууруулах.

2. Өр төлбөрийн данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын өр төлбөрийн үлдэгдэл өмнөх оноос 249.9 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын үр дүнтэй хэрэгжүүлэн, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, өр төлбөрийг 30-оос доошгүй хувиар бууруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэрс	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын ТТЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын ТШЗ	4	56,037.6	1	14,000.0	3	42,037.6	4	56,037.6	-	-	-	-
3	Архангай ХБХХТөв	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	Дорнод аймгийн ХБХХТөв	1	1,200.0	-	-	1	1,200.0	1	1,200.0	-	-	-	-
5	Дархан-Уул аймгийн ХБХХТөв	2	54,151.7	-	-	2	54,151.7	2	54,151.7	-	-	-	-
6	Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт хөгжлийн төв	2	73,398.9	-	-	-	-	-	73,398.9	-	-	-	-
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв	3	4,930.9	2	1,150.9	1	3,780.0	3	4,930.9	-	-	-	-
8	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв	2	46,306.6	2	46,306.6	-	-	2	46,306.6	-	-	-	-
9	Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төв	3	117,448.6	-	-	3	117,448.6	3	117,448.6	-	-	-	-
10	Дундговь аймаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	Ховд аймаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв	4	8,337.7	2	2,469.9	2	5,867.8	4	8,337.7	-	-	-	-
12	Хөвсгөл аймаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
НИЙТ ДҮН		21	361,812.0	7	63,927.4	14	297,884.6	21	361,812.0	-	-	-	-

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Үүнээс										Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага						
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын ТТЗ	2	356,136.1	-	-	-	-	2	356,136.1	-	-	-	-	-	-	-
2	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын ТШЗ	7	65,393.1	1	8,333.3	3	39,920.0	3	17,139.8	-	-	-	-	-	-	-
3	Архангай ХБХХТөв	2	49,614.0	-	-	2	49,614.0	-	-	-	-	-	-	-	-	-
4	Дорнод аймгийн ХБХХТөв	2	16,739.0	-	-	1	16,739.0	1	-	-	-	-	-	-	-	-
5	Дархан-Уул аймгийн ХБХХТөв	3	35,889.7	1	1,316.1	2	34,573.6	-	-	-	-	-	-	-	-	-
6	Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт хөгжлийн төв	5	96,288.5			3	68,347.8	2	27,940.7	-	-	-	-	-	-	-
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв	6	119,130.0	1	1,032.4	2	25,612.3	3	92,485.3	-	-	-	-	-	-	-
8	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв	14	2,063,542.1	3	3,574.7	10	2,043,047.4	1	16,920.0	-	-	-	-	-	-	-
9	Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төв	8	81,888.3	1	2,030.0	2	32,450.0	5	47,408.3	-	-	-	-	-	-	-
10	Дундговь аймаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв	1	1,608.0	1	1,608.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	Ховд аймаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв	2	700.0	-	-	-	-	2	700.0	-	-	-	-	-	-	-
12	Хөвсгөл аймаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв	2	18,585.0	-	-	-	-	2	18,585.0	-	-	-	-	-	-	-
	Дүн	54	2,905,513.8	8	17,894.5	25	2,310,304.1	21	577,315.2	-	-	-	-	-	-	-

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын ТШЗ	1	5,850.0	-	-	1	5,850.0	-	-
Архангай ХБХХТөв	1	41,531.2	-	-	-	-	1	41,531.2
Дорнод аймгийн ХБХХТөв	1	3,249,907.6	-	-	-	-	1	3,249,907.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв	1	1,394,430.9	-	-	-	-	1	1,394,430.9
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв	1	-	-	-	-	-	-	-
Ховд аймаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв	1	-	-	-	1	-	-	-
Дүн	6	4,691,719.7	-	-	2	5,850.0	3	4,685,869.7
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын ТТЗ	1	-	-	-	1	-	-	-
Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын ТШ	2	-	-	-	2	-	-	-
Дүн	3	-	-	-	3	-	-	-
Нийт дүн	9	4,691,719.7	-	-	5	5,850.0	3	4,685,869.7



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1093/А0171320

Улаанбаатар хот

САГ-2026/14/КА-СТА-ТТЗ

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа 11 байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 81 алдаа зөрчил илэрснээс санхүүгийн тайлантай холбоотой 361,812,800.00 (гурван зуун жаран нэгэн сая найман зуун арван хоёр мянга найман зуун) төгрөгийн 21 алдаа, 2,549,377,700.00 (хоёр тэрбум таван зуун дөчин есөн сая гурван зуун далан долоон мянга долоон зуун) төгрөгийн 52 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 4,691,719,700.00 (дөрвөн тэрбум зургаан зуун ерэн нэгэн сая долоон зуун арван есөн мянга долоон зуун) төгрөгийн 8 зөрчил илэрсэн нь төсвийн төвлөрүүлэн захирагчаас санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-т "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх"; 14 дүгээр зүйлийн 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх"; 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй зөрчлийг арилгах, алдаа зөрчлийг 15-оос доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газрын дарга (Д.Гэрэл), ерөнхий нягтлан бодогч (О.Содномпэрэнлэй) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ЭГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
С.БОЛОРТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 901-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

АТА15087
9025081411

Z:\Alban Sshaardlaga\2026\0325 SAG-20.Docx

1526181455